

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06-р сарын 27-ны өдөр

№ 25/41


Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/18 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зэргэлдээ компани болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай Давуу эрхийн хувьцааны борлуулалтыг дэмжих, компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор “Зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-ээр “Инвескор Капитал ҮЦК” ХХК-д төлөх борлуулалтын шимтгэлийн хувь хэмжээг 2.0 хувь хүртэл тухай бүр тохирох эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД


Ч. ХАШЧУЛУУН
Д. ЭНХБАТ
Ч. ӨНӨРЖАРГАЛ
Ш. ЭРДЭНЭБАТ